



ГОВЬСУМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 1142

Шивээговь сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн "Сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн

**ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1.Сумын 2023 оны "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн хөрөнгөөр хийгдэх "Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх сэргээн засварлах" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Г.Номин-Эрдэнэ

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Х.Дэлгэрэх

(Шивээ Овоо хувьцаат компанийн цахим мэдээллийн инженер)

Б.Базаррагчаа

(Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга)

72

Хөндлөнгийн төлөөлөл:

Ө.Баяржаргал

(Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга:

Б.Алтансүх

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг  
төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа  
хариуцсан мэргэжилтэн)

2. “Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх  
сэргээн засварлах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу  
хариуцлагатай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг үнэлгээний хорооны  
дарга (Г.Номин-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2023 оны 03 дугаар сарын 21-  
ний өдрийн А/34 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.СУГАРМАА

